“ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР БАРИХ ТӨСЛИЙН 35МВт ХҮЧИН ЧАДАЛТАЙ ШИНГЭН ТҮЛШЭЭР АЖИЛЛАХ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦАД БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

Танилцуулга

“Монгол улсад Газрын тос боловсруулах үйлдвэр (ГТБҮ) байгуулах төсөл” нь “Бүгд найрамдах Энэтхэг улс болон Монгол улсын Засгийн газар хооронд байгуулсан зээлийн ерөнхий хэлэлцээр”-ийн хүрээнд БНЭУ-ын Эскпорт-Импортын банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжиж байна.

Төслийн зорилго:

Дотоодын түүхий эдийн нөөцөд түшиглэн газрын тос боловсруулах үйлдвэр байгуулж, түлш шатахууны хэрэгцээгээ ханган, эдийн засагт нефть-химийн шинэ салбарыг бий болгоно.

Төсөл хэрэгжүүлэгч:

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК (”МГТБҮ” ХХК) нь ГТБҮ, Түүхий тос дамжуулах хоолой, үйлдвэрийн гаднах дэд бүтцийн байгууламжууд, “Газрын тосны үйлдвэрийн хотхон” байгуулах төслүүдийг хэрэгжүүлж байна.

ГТБҮ-ийн үндсэн өгөгдөл:

Хүчин чадал:	Жилд 1,5 сая тн тос боловсруулах
Үйлдвэрийн байршил:	Дорноговь аймаг, Алтанширээ сум
Боловсруулах тос:	Тосон уул XIX & Тамсаг XXI талбайн тос
Бүтээгдэхүүний чанар:	MNS & EURO V
Жилд ажиллах хугацаа:	8000 цаг
Гүн боловсруулалтын технологи:	Гидрокрекинг + Висбрекинг
Эрчим хүчний эх үүсвэр:	ДЦС 35 МВт

Үйлдвэрээс гарах бүтээгдэхүүн (жилд):

Шингэрүүлсэн шатдаг хий	27 мянган тонн
Авто бензин	396 мянган тонн
Дизель түлш	834 мянган тонн
Онгоцны түлш	80 мянган тонн
Зуухны түлш	17 мянган тонн

35 МВт-ын хүчин чадалтай шингэн түлшээр ажиллах дулаан, цахилгаан станцын суурь судалгааны өгөгдлүүд

- Зуух, туслах тоноглолууд
- Уурын турбин, туслах тоноглолууд
- Эргэлтийн усны тоноглол сонголт.
- Үйлдвэрийн барилгуудын халаалт, агааржуулалт, халуун усны хэрэгцээг хангах тоноглолуудын шаардлагатай үзүүлэлтүүд.
- ДЦС-ын гал эсэргүүцэх ба галын аюулаас хамгаалах систем
- Генератор ба туслах тоноглолууд
- Цахилгаан дамжуулах хаалттай хуваарилах байгууламж /дэд станц /
- Өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах кабель шугамын холболт

- Газрын тос боловсруулах үйлдвэрийн ДЦС-ыг холбох талаар
- Газрын тос боловсруулах үйлдвэрийн 110 кВ-ын дэд станцын өргөтгөл холбогдсон үеийн горим ажиллагаа.

Төсөл хэрэгжүүлэх үе шат

“Монгол улсад Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөл”-ийн бүтээн байгуулалтыг дэд бүтцийн дараалал, барилга байгууламж тус бүрийн төвөгшил болон инженерчлэлийн ажилд зарцуулагдах хугацааг тооцсоны үндсэн дээр дараах 4 хэсэгт хуваан гүйцэтгэж байна. Үүнд:

EPC 01: Технологийн бус барилга байгууламж
EPC 02: Атмосферийн болон Вакуум нэрлэг, Ханасан хий ялгах байгууламж, дагалдах, туслах байгууламжууд
EPC 03: Үйлдвэрийн Дулааны цахилгаан станц
EPC 04: Лицензтэй технологийн байгууламжууд

Төсөл хэрэгжүүлэх талбайн байршил

Газрын тос боловсруулах үйлдвэр нь цахилгаан, дулаан, технологийн уурын хэрэглээгээ хангах зорилгоор өөрийн 35 МВт-ын хүчин чадалтай дулаан цахилгаан станцтай байхаар төлөвлөгдсөн байна. Үйлдвэрийн төслийн менежментийн зөвлөх компани болон “Инженерс Индиа Лимитэд” компанийн саналаар Үйлдвэрийн дулааны цахилгаан станц нь тус бүр нь 17.5 МВт-ын хүчин чадалтай 2 иж бүрдэл уурын турбин генератор, 260 т/ц хүчин чадалтай нийт 2 иж бүрдэл уурын генератортой байна. Үйлдвэрийн дулаан, цахилгаан станцын эзлэх талбайн хэмжээ нь 25000 м2 буюу 2,5 га байна.

Зураг 1. Төслийн талбайн байршлын тойм зураг

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННҮ)

БОННҮ-ний ажлын зорилго, тавигдах үндсэн шаардлага

Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт баригдаж буй цахилгаан, дулаан, технологийн уурын хэрэглээгээ хангах зорилгоор өөрийн 35 МВт-ын хүчин чадалтай

дулаан цахилгаан станцын барих төслийн бүрэлдэхүүн ажлуудын нэг бөгөөд түүний хэрэгжилтийн үе шат бүрт байгаль орчин болон нийгэм, эдийн засаг, оршин суугчдын эрүүл мэндэд учруулж болзошгүй бүх нөлөөллийг тогтоох, үнэлэлт дүгнэлт өгөх, тэдгээр нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг холбогдох хууль тогтоомж, эрх зүй шаардлагын шалгуур үзүүлэлт, стандартад нийцүүлэх шаардлагатай арга зүй хамт тодорхойлсон явдал юм. БОННҮ-г гүйцэтгэхдээ Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачилсан заавар болон байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагуудын хүрээнд боловсруулах шаардлагатай. Төслийг Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яамны холбогдох мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх монгол хэл дээрх тайлангаас гадна Дэлхийн банкны Олон улсын санхүүгийн корпораци (International Finance Corporation)-аас гаргасан холбогдох стандартын дагуу шаардлагад нийцүүлэн монгол хэл, англи хэл дээр боловсруулна.

БОННҮ-ний хамрах хүрээ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн дараах бүрэлдэхүүн хэсгүүдийн хамруулна. Үүнд:

Газрын тос боловсруулах үйлдвэр нь цахилгаан, дулаан, технологийн уурын хэрэглээгээ хангах зорилгоор өөрийн 35 МВт-ын хүчин чадалтай дулаан цахилгаан станцын 25000 м2 буюу 2,5 га талбайд баригдах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг хамруулна.

- Зуух, туслах тоноглолууд
- Зуухны түлш хангамж
- Тэжээлийн усны систем.
- Утааны яндан
- Бохирдлын хяналтын систем (CO, NOx, SOX, нарийн ширхэгт тоосонцор зэрэг хаягдлын хяналт).
- Уурын турбин, туслах тоноглолууд
- гаарын хөргөлттэй конденсатор болон эргэлтийн усны тоноглол сонголт.
- Үйлдвэрийн болон иргэний барилгуудын халаалт, агааржуулалт, халуун усны хэрэгцээг хангах тоноглолуудын шаардлагатай үзүүлэлтүүд.
- ДЦС-ын гал эсэргүүцэх ба галын аюулаас хамгаалах систем
- Генератор ба туслах тоноглолууд
- Цахилгаан дамжуулах хаалттай хуваарилах байгууламж / дэд станц
- Өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах кабель шугамын холболт
- Хуваарилах байгууламж ба түүний тоног
- Газрын тос боловсруулах үйлдвэрийн ДЦС-ыг холбох талаар
- Газрын тос боловсруулах үйлдвэрийн 110 кВ-ын дэд станцын өргөтгөл

БОННҮ боловсруулах үйл явц

БОННҮ-г боловсруулах үйл явц дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг доорх үе шатуудаар дамжин гүйцэтгэнэ. Үүнд:

- Тухайн болон бүх үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн байгаль орчны бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлно;
- Үлдэгдэл нөлөөлөл, нөлөөллийн ноцтой байдлыг тогтоох;
- Төслийн болон БОННҮ-ний үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлох;
- Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тодорхойлох;
- Төслийн сөрөг нөлөөлөл багатай хувилбарыг сонгох;
- Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, үр дагаврыг арилгах арга хэмжээг тодорхойлох;
- Нөхөн сэргээх болон дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тогтоох;
- Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нутгийн оршин суугчдад учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээг хийх;
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах;
- Захиалагч болон төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хуралд тайланг танилцуулан хэлэлцүүлж санал авч, тайланд тусгах;
- БОУАӨЯ-нд заасан хугацаанд хүргүүлэн батлуулах;

БОННҮ-ний цар хүрээг тодорхойлох

Энэхүү БОННҮ гүйцэтгэх ажлын даалгавар, төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ болон техник эдийн засгийн үндэслэлийн үр дүн, нэгдсэн дүгнэлт болон холбогдох хууль тогтоомжид үндэслэн БОННҮ-ний цар хүрээг тодорхойлж, ажил гүйцэтгэх нарийвчилсан төлөвлөгөө, хуваарийг боловсруулж захиалагчид хүргүүлнэ.

Үйл ажиллагааны хүрээг тодорхойлох

Төсөл хэрэгжүүлэхэд зайлшгүй дагаж мөрдөх шаардлагатай үндэсний хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, эрх зүйн хөтөлбөр, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенц, хоёр талт гэрээ хэлэлцээр, тэдгээрийн хүрээнд хийсэн үүрэг амлалт, баримтлах стандарт, арга барилыг тодорхойлно.

Гүйцэтгэгч компани нь төслийн хууль, эрх зүйн хүрээнд хамаарах олон улсын гэрээ, хэлэлцээр, үндэсний хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн жагсаалт, түүнд тусгасан шаардлагуудыг гаргаж, БОННҮ-нд тусгана. Түүнчлэн судалгааны явцад шинээр гаргах шаардлагатай хууль эрх зүйн ба бодлогын асуудал гарах эсэхийг авч үзнэ.

Төслийн гол болон болзошгүй нөлөөллийг тодорхойлох, үнэлэх

Төслийн төлөвлөлт, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд тусгасан гол зорилго, техник технологи, эдийн засгийн хүчин чадал, үндсэн болон туслах үйл ажиллагааны хамрах хүрээ, онцлогийг тодорхойлон шинжилгээ хийх ба төслийн төлөвлөлт, барилга угсралт, үйл ажиллагаа болон хаалт, нөхөн сэргээлтийн үе шатанд байгаль орчин, нийгэм эдийн засгийн дараах бүрэлдэхүүн хэсгүүдэд учруулж болзошгүй гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг тодорхойлно.

- Агаарын чанар
- Газрын гадарга, хөрсөн бүрхэвч
- Гадаргын болон газрын доорх усны нөөц болон чанар
- Биологийн олон янз байдал
- Тусгай хамгаалалттай газар нутаг

- Соёлын биет болон биет бус өв
- Газар ашиглалт
- Ажилчдын болон нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдал
- Нийгэм, эдийн засаг
- Газар зүй мэдээллийн систем

Болзошгүй нөлөөллүүдийг тодорхойлсны дараа нөлөөллийн түвшинг харгалзах утгаар үнэлж тогтооно. Төслийн хэрэгжилттэй холбоотой, таамаглаж буй нөлөөллүүдийн ноцтой байдлыг харьцангуйгаар тогтоох, нөлөөллөөс зайлсхийх, нөлөөллийг бууруулах буюу дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг ямар нөлөөллүүдэд нэн түрүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатайг тодорхойлох зорилгоор нөлөөллийг үнэлж, дүгнэнэ.

Дээр дурьдсан байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн хэсгүүдэд учруулж болзошгүй нөлөөллүүдийг тодорхойлж, дараах шалгуур үзүүлэлтүүдээр үнэлнэ.

Үүнд:

- Нөлөөлөлд өртөгч;
- Нөлөөллийн хэлбэр (эерэг, сөрөг, шууд, шууд бус, хуримтлагдах);
- Зэрэглэл (их, дунд зэрэг, бага);
- Цар хүрээ (хамрах талбай/эзлэхүүн, тархалт);
- Хугацаа (бүтээн байгуулалтын шатанд, үйл ажиллагааны шатанд, хаалтын үед, тухайн үед, хожуу) ;
- Өөрчлөлтийн эрчим (их, дунд, бага);
- Үргэлжлэх хугацаа (богино хугацаанд, урт хугацаанд);
- Эргэж буцах шинж (түр зуурын эсвэл байнгын);
- Магадлал (магадлал, тодорхойгүй байдал);
- Ноцтой байдал (орон нутгийн, бүсийн, дэлхийн)
- Боломжит нөлөөллийн зэрэглэл

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ

Нөлөөллүүдийг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгсний дараа нөлөөллөөс зайлсхийх, бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх бодит, өртөг хэмнэсэн арга хэмжээнүүдийг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн шаардлагын шалгуур үзүүлэлт, шаардлагатай арга зүйн хамт тодорхойлно.

Техник технологи болоод санхүүгийн хувьд хэрэгжүүлэх боломжтой, өртөг хэмнэсэн нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг тодорхойлсны дараа дунд зэрэг буюу томоохон сөрөг үлдэгдэл нөлөөлөл байгаа эсэхийг тогтооно.

Эрсдэлийн үнэлгээ

Эрсдэлийн үнэлгээнд төсөлд ашиглагдах химийн хорт болон аюултай бодисын менежментийг тусгаж, эрсдэл үүсгэж болзошгүй бодисуудын талаар шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийнэ.

Мөн байгалийн аюул, гамшиг түүний тохиолдох магадлал, гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлж тусгана.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Төслийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон аливаа сөрөг нөлөөллийг урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах болон нөхөн хамгаалах төсөл хэрэгжих орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг төслийг хэрэгжүүлэх болон төслийн

ажиллагааны үеийн зардлыг тодорхойлох зорилгоор Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) боловсруулна.

БОМТ-д төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн хэсгүүд болох агаарын чанар, газрын гадарга болон хэвлий, газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг зэрэг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр нь авч үзэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулна.

Төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс төслийн нөлөөллийн бүс дэх байгаль орчин, нийгмийн нөлөөллийг хэрхэн удирдаж, тэдгээрийн эрчмийг бууруулах талаар авах арга хэмжээний талаар тусгана. Энэ нь төслийн барилгын болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үе шат дахь Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөг багтаах бөгөөд дараах хэсгүүдээс тогтоно:

- Болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулахын тулд авах арга хэмжээний цогц;
- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийг хангахад шаардлагатай байгууллагын бүтэц, чадавхижуулах шаардлагууд;
- Зөвлөмж болгосон сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа эсэх болон төслийн үйл ажиллагаанаас үүсэх нөлөөллийг хэмжих мониторингийн хөтөлбөр

Үүнээс гадна дараах дэд бүрдэл хэсгүүдийг төлөвлөгөөнд тусгана. Үүнд:

a. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
b. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө
c. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө
d. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө
e. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө
f. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
g. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө
h. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
i. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх

Оролцогч талуудын оролцоо, олон нийтийн хэлэлцүүлэг

Холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна.

Ажил гүйцэтгэх хугацаа, ажлын хуваарь, хүлээн авах үр дүн

Ажил гүйцэтгэх хугацаа, ажлын хуваарь

БОННҮ-ний тайланг англи болон монгол хэл дээр нийт 3 сарын хугацаанд боловсруулна. Гүйцэтгэгч компани нь гэрээнд гарын үсэг зурсан даруй ажлаа эхлэх ба БОННҮ боловсруулах ажлын нарийвчилсан төлөвлөгөөг Захиалагчид гэрээнд гарын үсэг зурснаас хойш 10 хоногийн дотор хүргүүлнэ.

N	Гүйцэтгэх ажил	Гүйцэтгэх хугацаа (хуанлийн хоног)
1.	Ажил гүйцэтгэх нарийвчилсан төлөвлөгөө	Төслийн талаарх мэдээллийг хүлээн авснаас хойш 10 хоног
2.	Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан	40 дэх хоног

3.	БОУАӨЯ-аар Ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулах	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4, 7.5-ын дагуу шийдвэрлэгдэнэ.
4.	IFC-ийн шаардлагын дагуу БОННҮ-ний тайлангийн төсөл англи хэл дээр (ерөнхий үнэлгээний дүгнэлтийн хугацаа хамаарахгүй)	75 дахь хоног
5.	БОННҮ-ний тайлангийн төсөл эцсийн хувилбараар БОУАӨЯ-нд хэлэлцүүлэхээр хүлээлгэн өгөх, монгол хэл дээр (БОННҮ-ний тайлан нь Ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасны дагуу хийгдэнэ)	85 дахь хоног
6.	БОУАӨЯ-аар БОННҮ-ний тайланг батлуулах	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн дагуу шийдвэрлэгдэнэ.

Хүлээн авах үр дүн

БОННҮ-ний тайлангийн төслийг монгол болон англи хэл дээр бэлтгэн захиалагчид хүргүүлэн санал авна.

Захиалагчийн зүгээс өгсөн саналын дагуу засварласан тайланг монгол хэл дээр БОУАӨЯ-ны Байгаль орчны үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулна.

Батлагдсан БОННҮ-ний тайланг монгол, англи хэл дээр тус бүр 3 хувь хэвлэмэл хэлбэрээр болон цахим хэлбэрээр (MS Word болон PDF форматаар) тус тус ирүүлнэ.

Мэдээ, мэдээлэл болон баримт бичгийн нууцлал, өмчлөл

Гүйцэтгэгч компанид хүргүүлсэн бүхий л мэдээ, мэдээлэл, оюуны өмчийн эрх, өмчлөл, тусгай зөвшөөрөл зэрэг нь зөвхөн тус төслийн хүрээнд хийгдэх судалгаа, үнэлгээний ажилд ашиглагдана.

Гүйцэтгэгч компанид хүргүүлсэн бичиг баримт болон мэдээ/мэдээллийг захиалагч компанийн бичгээр илэрхийлсэн зөвшөөрөлгүйгээр задруулахгүй.

Гүйцэтгэгч компанид тавигдах шаардлага

Гүйцэтгэгч компани нь ижил төстэй ажлын туршлагатай гүйцэтгэгч компани болон тэдгээрийн түншлэл байж болно. Ажил гүйцэтгэхээр шалгарсан гүйцэтгэгч компани нь өөрсдийн багийн чанарыг сайжруулах үүднээс бусад компанитай хамтарсан түншлэл хэлбэрээр эсвэл хамтран ажиллах дэд гэрээг байгуулан хамтрах боломжтой. Гүйцэтгэгч компанийн багт тухайлсан албан тушаалын үүрэг гүйцэтгэх мэргэжилтний нэр, ажлын туршлага чадварыг харуулсан тодорхойлолтыг бэлтгэнэ. Мөн гол ажиллах мэргэжилтнүүдийн нэрс, тэдгээрийн ажлын туршлага болон бусад холбогдох мэдээллийг техникийн саналд тусгасан байна. Ажил гүйцэтгэх хугацаанд ажиллах боломжтой бүхий л мэргэжилтнүүдийг баталгаажуулах, тэдгээрийн ажиллах чиглэл, хугацааг ажлын төлөвлөгөөнд дэлгэрэнгүй тусгасан байна.

Мэргэжилтэн		Тавигдах шаардлага
Үндсэн	• Багийн ахлагч • Химич • Ус зүйч, гидрогеологи	• Дэд бүтэц, хүнд үйлдвэрийн төслүүдийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээний чиглэлээр ажилласан туршлагатай байх,

	• Биологич, Амьтан судлаач • Хөрс судлаач • Орчны бохирдол, агаарын чанарын мэргэжилтэн • Ургамалын мэргэжилтэн • Дулаан цахилгааны инженер эсвэл Газрын тосны инженер	• Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний төсөл дээр ажилласан туршлагатай.

Гүйцэтгэгч компанид зайлшгүй байх шаардлагатай мэргэжилтнүүдэд тавигдах шаардлагыг тодорхойлсон болно. Гүйцэтгэгч компани нь өөрийн ажлын багийн бүрэлдэхүүнийг өөр хэлбэрээр ажиллуулах тухай санал гаргах, голлох мэргэжилтний дээрх жагсаалтад ороогүй бусад мэргэжлийн чиглэлээр мэргэжилтэнг нэмж ажиллуулж болно.